

Түр орогнох байр гэж юу вэ?

Танилцуулга хэсэг

Түр орогнох байр гэж юу вэ?

- “Түр орогнох байр” хэмээх үгийг сонсоход анх юу санаанд орсоноо бичнэ үү.
- How is it translated in Mongolian, are there different words? What do they mean?

Shelter in Mongolia Context



Орон байр бол хүний эрх юм

“Хүний эрхийн нийтлэг тунхаглалд” “орон байр”-ны үндсэн үзүүлэлтийг заахдаа:

- Аюулгүй байдал: “Хүн бүр аюулгүй, эрх чөлөөтэй амьдрах эрхтэй”
- Хувийн орон зай: Тухайн хүний хувийн орон зай, гэр бүл, гэр буюу түүнтэй адилтгах зүйл нь халдашгүй байна.
- Эзэмших: Хүн бүр өмч хөрөнгө эзэмших эрхтэй ба хэн ч дураар тухайн хүний эзэмшилд халдах эрхгүй.
- **Орон байр:** Хүн бүр өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл энх, сайхан амьдралын төлөө хоол хүнс, хувцас, орон байр, эрүүл мэндийн болон нийгмийн үйлчилгээг авах эрхтэй.

*Хүний эрхийн нийтлэг тунхаглал, 25-р зүйл:



Түр орон байрны тодорхойлолт

- Толь бичигт: “Цаг агаарын таагүй байдал, аюултай нөхцөл байдлаас түр хамгаалах газар”
- Бүлэг хүмүүс, гэр бүл, хувь хүмүүс амьдарч болох хүний хувийн орон зай, хүний нэр хүнд хамгаалагдсан, аюулгүй, эрүүл амьдрах орчин (Шилжин суурьшилт болон ахин байр сууцны ахин төлөвлөлтийн гамшгийн стратегийн дараах түр орон байр, 2015)
- Түр орон байр аюулт үзэгдлийн эхний үед амьд гарахад маш чухал шийдвэрлэх хүчин зүйлд тооцогддог. Зөвхөн амьд гарахаас гадна, хүний аюулгүй байдал, хувийн орон зайг хангах, нар салхинаас хамгаалах, халдварт өвчний тархалтаас сэргийлэх зэрэг үүрэгтэй. Түр орон байр нь хүн нэр төрөө хадгалж үлдэх, гэр бүлийн болоод нийгмийн бүлгийн амьдралыг хэцүү нөхцөл байдалд үргэлжлүүлэн авч явахад тусалдаг. (Сфер 2004)

Дасгал ажил

5 хүнтэй багууд скоч ашиглан шалан дээр оноогдсон түр орон байрыг тэмдэглэнэ:

Үүд нь хаана байна? Хэрхэн орох вэ?

Байрны дотоод зохион байгуулалтыг хэрхэн шийдсэн бэ? (Хаана унтах, хоол идэх гэх мэт)

Танай түр орон байранд хэрэгтээ байгаа зүйлс (Ор, зуух гэх мэт) ямар хэмжээтэй вэ? Мэдгээрийг хаана байрлуулах вэ?

Дасгал ажлын тухай

Ямар түр орон байр бий болгосон тухай бусаддаа танилцуулна уу, доорхи асуултанд заавал хариулаарай:

- Юу хамгийн хэцүү байсан бэ?
- Юу дутагдаж байсан бэ?
- Ямар мэдээлэлтэй байсан бол хэрэгцээтэй байх байсан бэ?

Шаардлага хангахуйц орон байр гэж юу вэ?

- Хангалттай хэмжээ бүхий
- Нар салхинаас хамгаалагдсан
- Аюулгүй байдал хангагдсан
- Амьдрах эрүүл орчин хангагдсан
- Хувийн орон зайтай
- Нэр төрд үл халдах



Нар салхинаас хамгаалагдсан? Хангалттай хэмжээ бүхий?



→ Хангалттай зайтай байх нь чухал! Сфер стандартад нэг хүнд дулаан орчинд 3.5, хүйтэн орчинд 4.5 м.кв гэж заасан байдаг.

→ Берзээнтэн бүтээлэг орон байр биш. Орон байрны анхдагч элементүүд болон бусад материалууд шаардлагатай.



Аюулгүй байдал?



- Түр орон байр аюулгүй, аливаа мөргөлдөөн эсвэл байгалийн гамшигт (хөлсний гулсалт, үер гэх мэт) эмзэг газраас хол, хөөн зайлуулагдах эрсдэлгүй газар байна.
- Түр орон байр нь бүтцийн хувьд бат бөх, газар хөдлөлтийн дараах чичиргээ болон хүчтэй салхинд тэсвэртэй байна.
- Хаалгаа түгжиж өөрийгөө болон эд зүйлээ хамгаалах боломжтой байна.



Хувийн орон зай, нэр хүнд?



→ Түр орон байрныхаа хэнхи хэсэгт босч зогсох боломжтой байх


- Хүсээгүйгээр бусдад үл харагдах (хувцасаа солихдоо) эсвэл хүсээгүй зүйлээ үл сонсох
- Түр орон байрны үндсэн нөхцөл нь цэвэрхэн байлгах боломжтой байх
- Бие засах, угаах, ус уух, хоол хүнс хэрэглэх боломжтой байх



Эрүүл амьдрах орчин нөхцөл



- Дулааны хангамж: халаалт, хөргөлт нь байх
- Амьсгалын замын болон халдварт өвчнөөс сэргийлэх агааржуулалттай байх
- Эрүүл ахуйн болон сэтгэл санааны хувьд тавтай байхын тулд хуурай, цэвэрхэн байх.



Shelter & Settlement

Хэрэгцээ хангахуйц орон байраар хангах нь зөвхөн нэг салангид зүйл бус орон байрыг тойрсон орчныг, үйлчилгээг бий болгох, энэ бүхнийг хэрхэн хэрэгжүүлж буй үйл явц юм.

Доорхи зүйлсийг авч үзэе:

- Усны хангамж – Угаах, цэвэрлэх, уух, ус зайлуулах
- Ариун цэвэр болон угаалгын газрууд; хог хаягдлыг цуглуулах
- Нэгдсэн гал тогоо, сургууль, эрүүл мэндийн төв зэрэг нэгдсэн үйлчилгээ
- Эмзэг бүлгүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэмжлэг
- Орчны хүмүүст үзүүлэх нөлөө болон хүмүүсийн орчинд үзүүлэх нөлөө
- Орон нутгийн соёл, амьдрах хэв маяг, уламжалт байгууламж
- Байгууламжын загвар гаргах, барихад нэрвэгдсэн өрхийн оролцоо
- Орон байрыг дараа нь оршин суугчдын саналаар сайжруулах боломжыг судлах

Түр орон байраар хангах үйл ажиллагаа

Аюулт үзэгдэлд хариу үзүүлэх

Аюулт үзэгдэл

Аюулт үзэгдлээс өмнө
Өрхүүд гэр бүлийнхээ эрүүл энх, сайн сайхан амьдралын төлөө өөрсдийн байр сууцыг үргэлж засч сэлбэж, томруулж, сайжруулж байна.

Аюулт үзэгдэлд хариу үзүүлэх
Holistic түр орон байраар хангах үйл ажиллагааг дэмжиж аажмаар сэргээн босгох

Аюулт үзэгдэлд хариу үзүүлсэний дараа
Өрхүүд гэр бүлийнхээ эрүүл энх, сайн сайхан амьдралын төлөө өөрсдийн байр сууцыг засч сэлбэх, томруулах, сайжруулах зэргээ үргэлжлүүлнэ.

Түр орон байртай болох боломжууд

- Бусад айлуудад хорогдох
- Нэрвэгдээгүй байгууламжуудаас түрээслэх
- Орон байраа яаралтай засч янзлах
- Аюулгүй нийтийн байгууламжууд (сургууль гэх мэт)
- Төлөвлөсөн түр байршлын бүсэд гэрт амьдрах
- Төлөвлөсөн түр байршлын бүсэд өвлийн майханд байрлах (ганцаараа эсвэл нийтээрээ)
- Дээрхи бүгд тохирох хүнсний бус бүтээгдэхүүнүүд болон халаалт, түлштэй цуг дагалдах ёстой

Тусламжийн аргазүй: Биет

Биет зүйлс нь түр орон байрыг барих, засч сэлбэх, өрхийн хэрэгцээг хангахад хэрэглэгдэнэ.

■ Гамшгийн үед

- Бүтээлгийн багц (2 бэрзээнтэн бүтээлэг + олс)
- Орон байрны багц (2 бэрзээнтэн бүтээлэг + олс + тогтоогч)
- Майхан
- Өрхийн хүнсний бус зүйлс (Ор, зуух, гал тогооны хэрэгсэл гэх мэт.)

■ Нөхөн сэргээх


- Завсрын буюу шилжилтийн орон байр(Т-орон байр, контейнэр гэх мэт)
- Барилгын материал
- Барилгын хэрэгсэл
- Зам харгуй болон дэд бүтцийг ашиглалтанд оруулах



Туслажийн арга зүй: Биет бус

Туслажийг үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг бий болгох.


- Техникийн зөвлөгөө бүхий тараах материалууд.
- Барьж байгуулах, төлөвлөхөд мэргэжлийн зөвлөгөө өгөх.
- Аюулгүй барьж байгуулах сургалт зохион байгуулах
- Түр орон байр, байшингийн загвар үзүүлэнг бэлтгэх
- Албан ёсны түрээсийн гэрээ боловсруулах, газар эзэмших тухай зөвлөгөө өгөх зэрэг хуулийн




Тусламжийн арга зүй: Бусад

Хэрэгцээ хангахуйц орон байраар хангах зорилгод хүргэх бусад шийдлүүд.

- Засгийн газар, удирдлагуудтай хамтран ажиллаж албадан хөөн зайлуулах, эзэмших албан ёсны эрх авах түдгэлзэх зэрэг асуудлыг шийдвэрлэх бодлогыг бий болгох.
- Түр орон байр барьж эсвэл байгуулж болох аюулгүй газар эсвэл байгууламжуудыг тогтоох
- Санхүүгийн боломжит нөөцийг бий болго. (мөнгөн тусламжийн хөтөлбөр, даатгал, зээл, эрхийн бичиг)



Сэргээн босгох замнал



Pathway to Recovery



first three weeks in collective shelter



6 months in camp



6 months rental support to move into repaired building